



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 11 сарын 11 өдөр

Дугаар 11382

Улаанбаатар хот

“Оны онцлох хүүхэд” шалгаруулах ажлын
хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3 дахь заалт, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны “Хүүхэд залуучуудын хөгжил, хамгаалал-2028” арга хэмжээ батлах тухай 07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Оюун ухаан, сурлага хүмүүжил, авьяас чадвар, хүмүүнлэг энэрэнгүй үйлсээрээ үе тэнгийнхнээ манлайлсан хүүхдүүдийг “Оны онцлох хүүхэд”-ээр өргөмжлөн шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ахлагч:	Н.Бямбагэрэл	Засаг даргын орлогч
Гишүүд:	Л.Баярмаа	Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга
	Ц.Цолмонбаатар	Боловсролын хэлтсийн дарга
	А.Лхагвадорж	Соёлын төвийн дарга
	Р.Очирпүрэв	Биеийн тамир, спортын хорооны дарга
	Б.Болортунгалаг	Хүүхэд хөгжлийн цогцолбор УТҮГ-ын дарга
Нарийн бичиг:	Х.Азбаяр	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтсийн дарга

2.Дээрх үйл ажиллагааг холбогдох хууль журмын дагуу зохион байгуулж, мэдээллийг холбогдох байгууллагад хүргүүлж ажиллахыг Ажлын хэсэг (Н.Бямбагэрэл)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газар (Ж.Тамир)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Н.МАНДУУЛ

1525011182